

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**



АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

**АУДИТЫН СЭДЭВ: УЛСЫН ТӨСВИЙН 2024 ОНЫ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ**

АУДИТ ХИЙСЭН ҮНДЭСЛЭЛ, БҮРЭН ЭРХ: Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2024 оны 05 дугаар тогтоолд тусгасны дагуу аудитын хийж гүйцэтгэлээ.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ☐ Тендерийн баримт бичиг, ажлын даалгаврын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулж, үр дүнтэй зохион байгуулаагүйгээс 15,241.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ хэрэгжих боломж алдагджээ.

ТАЙЛАНГ ХҮРГҮҮЛСЭН ЭТГЭЭД: Ховд аймгийн Засаг дарга, Орон нутгийн өмчийн газар, Худалдан авах ажиллагааны газар, **Боловсролын газар**, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар

НЭМЭЛТ МЭДЭЭЛЭЛ, МЭДЭЭЛЛИЙН ЭХ СУРВАЛЖ: Ховд аймаг дахь Төрийн аудитын газар, холбоо барих утас 70433061

Ховд хот

2025.04.29

АУДИТЫН ТАЛААРХ ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ:

Аудитын хураангуй тайлангийн зорилго, зорилтууд, хамарсан хүрээ:

Улс төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд аудит хийж, дүгнэлт өгч, зөвлөмж боловсруулан дүнг УАГ-ын ГНАГ, аймгийн ИТХ, Засаг дарга болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилгыг чиглүүлж, аудитыг дараах дэд зорилтын хүрээнд гүйцэтгэлээ. Үүнд:

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд хууль, журамд заасан шаардлага хангасан төсөл, арга хэмжээг төлөвлөсөн эсэх.
- Хөрөнгө оруулалтаар төлөвлөсөн төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг хууль, журмын дагуу зохион байгуулсан эсэх.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хууль журмын дагуу санхүүжүүлж, хугацаанд нь гүйцэтгүүлэн бүртгэлд тусгасан эсэх.

Улс төсвийн 2024 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагаа, санхүүжилт, хэрэгжилтийг зохион байгуулсан Төсвийн ерөнхийлөн захирагч, ХОХБТХ, Санхүү төрийн сангийн хэлтэс, Худалдан авах ажиллагааны газар болон Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар, сумдын Засаг даргын Тамгын газар болон холбогдох бусад байгууллагыг хамруулан төсөл, арга хэмжээний төлөвлөлтийн баримт бичиг, ажлын даалгавар, ТЭЗҮ, зураг төсөл, магадлалын ерөнхий дүгнэлт, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, тайлан, гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээ, олгосон санхүүжилт, төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хамруулж горим сорилыг хэрэгжүүлсэн болно.

Аудитын хүндрэл бэрхшээл

Аудитын явцад төсвийн ерөнхийлөн захирагч, зарим ажил хариуцсан албан хаагч солигдсон, төрийн байгууллагуудын ажил хариуцаж байгаа зарим мэргэжилтнүүдийн ажилдаа хандах хандлага сул, холбогдох мэдээ мэдээллийг цагт нь ирүүлдэггүй, хариуцсан ажлын талаарх дэлгэрэнгүй тоо мэдээ, судалгаа бүрэн бус, архивын нэгж үүсээгүй, зарим төсөл арга хэмжээг гүйцэтгэсэн аж ахуйн нэгжээс санал тайлбар авахад бэрхшээл үүссэн зэрэг асуудлууд аудитыг гүйцэтгэхэд хүндрэлтэй байлаа.

БҮЛЭГ 1. УЛСЫН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТААР ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭГ АРГАЧЛАЛЫН ДАГУУ ҮНЭЛЖ ЭРЭМБЭЛЭЭГҮЙ, ТӨЛӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГА ХАНГААГҮЙ ЗАРИМ ТӨСӨЛ АРГА ХЭМЖЭЭГ ТӨЛӨВЛӨСӨН НЬ ХУГАЦААНДАА ХЭРЭГЖИХГҮЙ УДААШИРЧ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮР ӨГӨӨЖИЙГ БУУРУУЛЖ БАЙНА

Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 төсөл арга хэмжээг 2024 онд төлөвлөгөөгүй байна

1.1.1 Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан улсын төсвөөс санхүүжүүлэх төсөл арга хэмжээг бүрэн тусгаж, хэрэгжүүлэх чиглэл баримтлахаар төлөвлөжээ.

1.1.2 Гэтэл Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан дараах 2 төсөл арга хэмжээг Монгол Улсын 2024 оны Төсвийн тухай хуульд батлаагүй байна. Үүнд:

- *Ховд аймгийн “Ховд” нисэх буудлыг 4С ангиллын агаарын хөлөг хүлээн авах хүчин чадалтай аэродром, зорчигч үйлчилгээний цогцолборыг байгуулах*

• *Бүсийн шүүх шинжилгээний төв байгуулах /Дорнод, Ховд, Дархан/*

1.1.3 Ховд аймагт 2024 онд шинээр хэрэгжихээр батлагдсан 45 төсөл, арга хэмжээ нь Монгол улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Монгол Улсын Засгийн газрын “2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Монгол Улсын “2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” зэрэг урт болон дунд хугацааны бодлоготой уялдсан байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөсөн эсэх нь тодорхой бус байна

1.2.1 2024 онд Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний саналд нийт 671,665.8 тэрбум төгрөгийн өртөгтэй 121 төсөл арга хэмжээг төлөвлөн хүргүүлсэн байна.

1.2.2 Дээрх санал хүргүүлсэн төсөл арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж, эрэмбэлээгүй, ажлын хэсгийн тайлан, баримт материал ирүүлээгүй, архивын нэгж үүсгээгүй байх тул эдийн засгийн үр ашиг, нийгмийг ач холбогдлыг тооцсоныг үнэлэх боломжгүй байна.

1.2.3 УТХО-ын төлөвлөлтийг цахим системээр төлөвлөж байгааг хянахад шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 121 ажлаас цахим системд 17 төсөл арга хэмжээг бүрэн оруулж, 104 төсөл арга хэмжээ буюу 86 хувийг цахим системд мэдээлээгүй байна.

1.2.4 Тухайн жилд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний саналыг төсвийн төсөлд тусгуулахаар хүргүүлэхдээ хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлээгүй, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх санхүүжилтийн эх үүсвэрийг оновчтой тооцохгүйгээр Засаг даргын зөвлөлөөр хэлэлцэн хүргэж байгаа, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг цахим системээр бүрэн төлөвлөөгүй нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол болон Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан заавар аргачлалыг мөрдөөгүй, хэрэгжилт хангалтгүй байна.

Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг тусгасан, санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй байна

1.3.1 Ховд аймагт 11 төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 22, тухайн оноос эхлэн хэрэгжих 44, нийт 546,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 66 төсөл, арга хэмжээг 154.2 тэрбум төгрөгөөр санхүүжүүлэхээр баталжээ.

Хүснэгт 1:Шинэ болон шилжэх ТАХ
сая.төг

Ангилал	Шинэ ТАХ			Шилжих ТАХ			Нийт ТАХ		
	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
Барилга байгууламж	33.0	322.4	79.0	22.0	211.6	62.6	55.0	533.9	141.6
Тоног төхөөрөмж	11.0	12.6	12.6				11.0	12.6	12.6
Нийт	44.0	335.0	91.6	22.0	211.6	62.6	66.0	546.5	154.2

Эх сурвалж:МУ-ын 2024 оны төсвийн тухай хууль

1.3.2 Өмнөх оноос үргэлжлэн хэрэгжих 22 төсөл, арга хэмжээг Төсвийн тухай хуулийн 2024 онд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын жагсаалтад бүрэн тусгасан байна.

1.3.3 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгасан шинээр эхлүүлэх эрх шилжиж ирсэн 22 төсөл, арга хэмжээнээс барилга байгууламжийн ангиллын 14 төсөл арга

хэмжээний 5 төсөл арга хэмжээ нь магадлалаар баталгаажсан зураг, төсөвтэй байх шаардлагыг хангаагүй, Төсөв батлагдсаны дараа магадлалаар хянуулсан нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан "Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам"-ын 3.2.2.2²-т заасан шаардлагатай нийцээгүй байна.

1.3.4 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй, төсөвт өртгөөс тухайн жилд ногдох санхүүжилтийг тэнцүү хуваарилах байдлаар тооцож батлаагүй 275,303.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 төсөл арга хэмжээний санхүүжих дүнг 42,226.4 сая төгрөгөөр дутуу төлөвлөн баталсан байна. Үүнд:

Хүснэгт 2: ТАХ-ний тухайн онд санхүүжих дүнг уялдаагүй төлөвлөсөн сая.төг

Д/Д	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	2024 оны төсөвт өртөг	Хуулиар батлагдах дүн	Хуулиар батлагдсан дүн	Зөрүү
1	Цагдаагийн газрын барилга /Ховд, Жаргалант сум/	2024	2026	8,576.9	2,859.0	1,753.8	1,105.2
2	Оюутны дотуур байрны барилга /Ховд/	2024	2026	12,606.8	4,202.3	1,000.0	3,202.3
3	Сургуулийн барилгын өргөтгөл, 320 суудал /Ховд, Жаргалант сум, 2 дугаар баг, 7 дугаар сургууль/	2024	2026	9,507.7	3,169.2	2,852.3	316.9
4	Цэцэрлэгийн барилга, 240 ор /Ховд, Жаргалант сум, 7 дугаар баг, 2 дугаар цэцэрлэг/	2024	2026	5,200.0	1,733.3	1,560.0	173.3
5	Баруун босоо тэнхлэгийн авто замаас Ховд аймгийн Мөнххайрхан сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 63.5 км /Ховд, Мөнххайрхан сум/	2024	2026	70,105.1	23,368.4	8,500.0	14,868.4
6	Нутгийн зам төслийн хүрээнд хэрэгжүүлэх хатуу хучилттай авто зам /Ховд, Булган, Буянт сум/	2024	2025	22,661.8	11,330.9	9,577.1	1,753.8
7	Ховд-Дөргөн сум чиглэлийн хатуу хучилттай авто зам, 40.7 км /Ховд, Дөргөн сум/	2024	2026	49,859.3	16,619.8	5,539.9	11,079.9
8	Хэвтээ тэнхлэгийн хатуу хучилттай авто замтай Цэцэг сумыг холбох хатуу хучилттай авто зам, 32.4 км /Ховд, Дарви сум/	2024	2026	32,580.5	10,860.2	5,027.9	5,832.3
9	Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/	2024	2026	38,071.2	12,690.4	11,421.4	1,269.0
10	Гэр хорооллын цэвэр, бохир усны шугам сүлжээ, бохир усны гол магистрал шугам 2 дугаар ээлж /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт, Тахилт, Алагтолгой, Бугат, Буянт, Хайрхан баг/	2024	2026	12,620.0	4,206.7	3,786.0	420.7
11	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Жаргалант сум/	2024	2026	1,500.0	500.0	300.0	200.0

¹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгоогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

² Барилга байгууламжийн хувьд сүүлийн 2 жилийн дотор хийгдсэн магадлалын ерөнхий дүгнэлтээр баталгаажсан зураг төсөл болон төсөвтэй байх;

12	Услалтын системийн шинэчлэл /Ховд, Дарви сум/	2024	2026	12,014.2	4,004.7	2,000.0	2,004.7
Дүн				275,303.5	95,544.8	53,318.4	42,226.4

Эх сурвалж:МУ-ын 2024 оны Төсвийн тухай хууль

1.3.5 Дээрх байдлаар хөрөнгө оруулалтын ТАХ-ний тухайн жилийн санхүүжих дүнг оновчтой төлөвлөхгүй байгаа нь ТАХ-г хугацаанд нь хэрэгжүүлэх боломжийг хязгаарлаж, он дамжин олон жил үргэлжлэх, хүрэх үр дүнг бууруулах эрсдэлийг дагуулж байна.

1.3.6 Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний холболт, дэд бүтцийн асуудлыг иж бүрэн байдлаар төлөвлөж, хэрэгжүүлээгүйгээс төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжихгүй байх, нэмэлт төсөв гарах эрсдэл үүссэн байна.

1.3.7 Тайлант онд хэрэгжих 1,560.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийн барилга худалдан авах, 75 ор /Ховд, Жаргалант сум/ төсөл арга хэмжээг төлөвлөхдөө тухайн нэр заасан барилгыг худалдан авахаар санал хүргүүлсэн нь төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор батлагдсан Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмыг зөрчсөн.

1.3.8 Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг төлөвлөж байгаа нь батлагдсан төсөвт тааруулан ажлын тоо хэмжээг багасгах, барилга байгууламжийн инженерийн шугам сүлжээ, дэд бүтэц, тохижилтын ажил иж бүрэн хийгдэхгүй орхигдох, ХБТХОХ-ийн төлөвлөлтийн бодлого, шийдвэр тогтворгүйгээс ТАХ төлөвлөсөн хугацаанд хэрэгжихгүй удаашрах, төсөвт өртөг нэмэгдэх зэрэг асуудлын суурь шалтгаан болж байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, 5,700.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг төлөвлөжээ

1.4.1 2024 онд хэрэгжүүлэхээр тусгасан 45 төсөл арга хэмжээ нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24³-д заасны дагуу тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд бүрэн шилжих хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

1.4.2 Дээрх төлөвлөсөн төсөл арга хэмжээнээс төрийн хэмнэлтийн тухай хууль зөрчсөн 4 төсөл арга хэмжээ байна. Үүнд :

- *Соёлын салбарын тоног төхөөрөмж төсөл арга хэмжээнд сумдын багийн төвд ашиглах тоног төхөөрөмж төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.1⁴-д заасантай нийцээгүй,*
- *Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Мөнххайрхан, Буянт, Мөст, Ховд, Эрдэнэбүрэн сум/, Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Жаргалант сум/, Ховд аймгийн Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань суманд хэрэгжүүлэх ногоон байгууламж бүхий орчны тохижилтын ажил - Багц 1 төсөл арга хэмжээнүүд нь орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, гэрэлтүүлэг, тохижилтын ажлыг төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.4⁵-д заасантай нийцээгүй*

³ "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг"

⁴ орон нутгийн нийтийн эзэмшлийн зам, талбай, олон нийтийн соёл амралтын хүрээлэн, хаягжуулалт, гэрэлтүүлэг, тохижилт;

⁵ багийн төв, хорооны засаг захиргааны зориулалттай барилга барих, тохижуулах, засварлах, тоног төхөөрөмж худалдан авах;

1.4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн төсөл арга хэмжээ төлөвлөсөн нь тухайн төсөл арга хэмжээний санхүүжилт олгогдохгүй удааширч, төлөвлөсөн хугацаандаа хэрэгжих боломжгүй нөхцөл байдлыг үүсгэсэн байна.

БҮЛЭГ 2. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, АЖЛЫН ДААЛГАВАРЫГ ОНОВЧТОЙ БОЛОВСРУУЛААГҮЙ НЬ БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАРТ СӨРГӨӨР НӨЛӨӨЛЖЭЭ

Аймгийн Засаг даргад 91,558.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл арга хэмжээг 8 сайдын багцаас эрх шилжүүлж, 21 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулсан байна

2.1.1 Монгол улсын ЗГ-ын 2023 оны 409 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралтаар “Монгол улсын 2024 оны төсвийн хөрөнгөөр аймаг нийслэлд эрх шилжүүлэн хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтыг баталсаны дагуу Ховд аймагт 2024 онд хэрэгжүүлэх 91,758.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 ТАХ -ний эрхийг 8 ТЭЗ -аас Ховд аймгийн засаг даргад эрх шилжүүлсэн байна.

2.1.2 Ховд аймагт хэрэгжих 21 төсөл арга хэмжээний эрхийг хуулийн хугацаанд шилжүүлэн ЗТЯС-ын багцын “Ногоон байгууламж бүхий орчны тохижилт” /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/ төсөл арга хэмжээний эрх шилжүүлэх шийдвэр 2024 оны 05 сарын 22-ны өдрийн А/120 дугаар тушаалаар батлагдаж ирсэн нь Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 4.1.1⁶ -т заасантай нийцээгүй байна.

2.1.3 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 22 төсөл арга хэмжээнээс төсөвт өртөгт үндэслэн 91,558.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 21 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтын аргаар, 100.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээг харьцуулалтын аргаар тус тус зарласан нь Засгийн газрын 2024 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн 02 дугаар тогтоолын хавсралтаар баталсан төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил, үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаарыг тогтоосонтой нийцжээ.

2.1.4 Гэвч НТШ аргаар амжилтгүй болсон худалдан авах ажиллагааг дахин зарлах хуулийн зохицуулалтай байхад дараах ажлыг гэрээ шууд байгуулсан нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.3⁷-д заасныг зөрчсөн байна. Үүнд:

- *ЗТЯС-ын багцын 3000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/ ТАХ -ний багц-9 Дулааны шугам сүлжээний засварын ажлыг НТШ аргаар 1 удаа зарлаж амжилтгүй болсон ч гэрээ шууд байгуулсан,*

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журам, стандартад нийцүүлэн боловсруулаагүйгээс зарим шаардлагагүй тоног төхөөрөмж нийлүүлжээ

⁶ “Төсвийн ерөнхийлөн захирагч нь төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдуулан тухайн жилийн 01 дүгээр сарын 20-ны өдрийн дотор багтаан дараах эрхээ доор дурдсаны дагуу шилжүүлж болох бөгөөд энэ талаар гаргасан шийдвэрээ ажлын 5 хоногт багтаан цахим системд оруулж, баталгаажуулна”

⁷ “Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно”

2.2.1 Аймгийн Засаг дарга 22 төсөл арга хэмжээнээс 8 төсөл арга хэмжээг ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10.5⁸-д заасны дагуу нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан багцалжээ.

2.2.2 Дээрх байдлаар багцлахдаа “Эрүүл мэндийн салбарын тоног төхөөрөмж /Ховд/ төсөл арга хэмжээ”-д компьютер, техник тоног төхөөрөмжийг 2 тусдаа багц болгосон, хуулийн нэршилд заагаагүй сумыг оруулж багцалжээ.

2.2.3 ТБОНӨХБАҮХАТ хуульд заасны дагуу үнэлгээний хороог аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар байгуулж ажилласан байна.

2.2.4 “Ховд хотын ундны усны эх үүсвэр(Ховд, Жаргалант сум)” төсөл арга хэмжээний худалдан авах арга хэмжээг зохион байгуулахад оролцогчоос гомдол гаргаж Сангийн яамнаас хянаж үзээд үнэлгээний хорооны гишүүд нь “.. тендерийн баримт бичигт тусгагдсан шалгуур үзүүлэлтийг хангаагүй, зөрчилтэй тендерт оролцогчийг дэмжсэн, хэт нэг талыг барьж ажилласан асуудлууд илэрсэн байхад үнэлгээний хорооны гишүүдэд хариуцлага тооцоогүй байгаа нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 52 дугаар зүйлийн 52.5⁹дэх заалтын хэрэгжилт хангагдахгүй байна.

2.2.5 Тайлант онд хэрэгжих 1,560.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй цэцэрлэгийн барилга худалдан авах, 75 ор /Ховд, Жаргалант сум/ төсөл арга хэмжээний техникийн тодорхойлолтыг боловсруулахдаа БХБС-ын 2022 оны 193 дугаар тушаалаар баталсан “Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын барилгын төлөвлөлт” Монгол улсын барилгын норм дүрэмд заасан үзүүлэлтүүдийг тодорхой тусгаагүй, ХААГ нь гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахдаа техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг бүрэн хангаагүй, тус барилгын гадна зай талбайд нэмэлтээр тоглоомын талбай, хашаа ногоон байгууламж, авто машины зогсоол хийх боломжгүй, тал бүрээс орон сууцаар хүрээлэгдсэн байршилд байхад гүйцэтгэгчийг шалгаруулж, гэрээ байгуулах эрх олгосон нь ТБОНӨХБАҮХАТХуулийн 12 дугаар зүйлийн 12.1¹⁰, 26 дугаар зүйлийн 26.4.2¹¹ холбогдох хууль журмуудыг зөрчсөн байна.

2.2.6.Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4-д заасан “хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэснийг зөрчин дараах 5 ТАХ-г тодорхой норм дүрэм, стандартгүй, ажлын даалгавраар худалдан авах ажиллагааг зарласан байна.

2.2.7.Зарим төсөл арга хэмжээний төсөв батлагдсаны дараа ажлын даалгавар, зураг төсвийг боловсруулсан 14,360.0 сая төгрөгийн зөрчил нь Төсвийн тухай хуулийн 29.4-т заасан заалттай нийцэхгүй байна. Тухайлбал:

- Цэцэрлэгийн барилга худалдан авах, 75 ор /Ховд, Жаргалант сум/
- Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол болон ерөнхий боловсролын сургуулийн номын фонд, тоног төхөөрөмж /Ховд/
- Цахилгаан хангамж /Ховд, Булган сум/
- Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Мөнххайрхан, Буянт, Мөст, Ховд, Эрдэнэбүрэн сум/
- Соёлын салбарын тоног төхөөрөмж /Ховд/
- Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/
- Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Жаргалант сум/
- Музейн, номын сангийн өргөтгөлийн барилга /Ховд, Дарви сум/

⁸ “Захиалагч өрсөлдөөнийг дэмжих зорилгоор бараа, ажил, үйлчилгээг зориулалт, нэр төрөл, газар зүйн байрлалыг харгалзан нэг төрлийн болон ижил төстэй байдлаар багцалж болно”

⁹ 52.5.Энэ хуулийн 52.1-д заасан ажилтан, албан тушаалтан дараах үүргийн аль нэгийг хэрэгжүүлээгүй нь түүнийг тухайн худалдан авах ажиллагаатай холбоотой чиг үүргээс чөлөөлж, эрх бүхий этгээд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэх үндэслэл болно:

¹⁰ 12.1.Захиалагч техникийн тодорхойлолтод бараа, ажил, үйлчилгээний шаардлагатай гэж үзсэн шинж чанар, түүний зориулалт болон зориулалтын дагуу ашиглахтай холбоотой шаардлага, зураг төсөл, холбогдох стандарт, норм, дүрэм, зааврыг тусгана.

¹¹ 26.4.2.Санал болгосон бараа, ажил, үйлчилгээ техникийн тодорхойлолтод нийцсэн байх;

- Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/

2.2.8 Ахмадын хөгжлийн, Соёлын, Эрүүл мэндийн, Боловсролын салбарын тоног төхөөрөмж, худалдан авах төсөл арга хэмжээний ажлын даалгаврыг боловсруулахдаа хэрэгцээ шаардлагад үндэслээгүй, үр ашиггүй дараах хөрөнгүүдийг бэлтгэхээр тусгасан нь улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулсан байна. Үүнд:

- Хүчилтөрөгчийн коктейлний аппарат 17 ширхэг,
- Анхны тусламжийн багцын хайрцаг 220 ширхэг,
- Сумдын эрүүл мэндийн төвүүд нь 10 орны хүчин чадалтай байхад 50 л багтаамжтай 1, 2-р хоолны тогоо, жигнүүр
- Буйдан, массажны сандал, оффис буйдан, кофе чанагч гэсэн 35 нэр төрлийн 4.7 сая төгрөгийн тавилга эд хогшил
- Аяга таваг угаагч нь нэг угаалтаар 15 хүний стандарт хоолны хэрэгсэл угаах багтаамжтай тул олон хүүхэдтэй цэцэрлэгт хэрэглэхэд цаг зарцуулалтын хувьд хүндрэлтэй

2.2.9 Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төслийн 9 дүгээр багцын ажлын даалгаврыг ШХББХК нь "Шинэ хөдөө төслийн сургалт сурталчилгаа, нутагшуулалт" гэсэн урсгал зардлыг багц болгон санхүүжүүлэхээр ажлын даалгавар боловсруулсан төслийн нэгж болох Ховд Агро паркыг тендерт гүйцэтгэгчээр шалгаруулсан нь ТБООЭХБАҮХАТ хуулийн 52 дугаар зүйлийн 52.1¹², 52.5.3¹³-д заасан заалттай нийцэхгүй байна.

Тендерийн баримт бичиг, ажлын даалгаврын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулж, үр дүнтэй зохион байгуулаагүйгээс 15,241.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ хэрэгжих боломж алдагджээ

2.3.1 2024 онд хэрэгжүүлэхээр батлагдсан 22 ТАХ-г 62 багц болгон задалж худалдан авах ажиллагааг зарласны 48 ТАХ-ны худалдан авах ажиллагаа амжилттай болж, 14 багц ажил амжилтгүй болсон байна.

Хүснэгт 3: Нийт ТАХ-ээс хэрэгжсэн болон хэрэгжээгүй төслийн мэдээ: сая.төг

Төслийн ангилал	Батлагдсан		Амжилттай болсон		Амжилтгүй болсон	
	Төслийн тоо	Төсөвт өртөг	Төслийн тоо	Төсөвт өртөг	Төслийн тоо	Төсөвт өртөг
Төслийн тоогоор	22	91,658.26	17	76,417.26	5	15,241.00
Багц төслийн тоогоор	62	91,658.26	48	76,417.26	14	15,241.00

Эх сурвалж. *Tender.gov.mn*.

2.3.2 Батлагдсан хөрөнгө оруулалтын ажлуудын худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулсан ч зарим хөрөнгө оруулалтын ажлуудад оролцогч ирээгүйгээс

¹² Худалдан авах ажиллагаанд төлөвлөх, бэлтгэх, хэрэгжүүлэх, тендер хянан үзэх, үнэлэх, хяналт тавих, тайлагнах, гомдол хянан шийдвэрлэх чиг үүрэг бүхий ажилтан, албан тушаалтан энэ хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид заасны дагуу ашиг сонирхлын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, ашиг сонирхлын зөрчил үүссэн тухайгаа, түүнчлэн албан үүрэгт хөндлөнгөөс нөлөөлөх байдлыг тус тус мэдэгдэх үүргийг хүлээнэ.

¹³ худалдан авах ажиллагаанд холбогдох чиг үүргээ хэрэгжүүлэхдээ Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиар тогтоосон хориглолт, хязгаарлалтыг зөрчсөн.

4-6 удаа зарлаж, гүйцэтгэгч сонгон шалгараагүй байгаа тул тендерийн баримт бичиг, ажлын даалгаврын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулж үр дүнтэй ажиллах шаардлагатай байна. Үүнд:

- Нийтийн эзэмшлийн зам талбайн тохижилт /Ховд, Жаргалант сум/ 4 удаа тендер зарласан боловч гүйцэтгэгч ороогүй
- Буянт сум дахь Ховд агро парк төслийн газарт услалтын системийн толгойн байгууламж 1000 метр хар хоолойн угсрах ажил: 4 удаа зарласан ч гүйцэтгэгч шалгараагүй,
- Жаргалант сумын тоглоомын талбай бүхий орчны тохижилт-Парк усжуулалт, Жишиг гудамж бүхий орчны тохижилт (Жаргалант сум)-Парк усжуулалт Төв гудамжнаас Өөлдийн хорооллын авто зам, явган замын ажил, Бичигт, Баатархайрхан багийн дундах цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, Залуусын Жишиг гудамж бүхий орчны тохижилт: Энэхүү багц ажлын худалдан авах ажиллагааг 5 удаа зарлаж, тендерийн баримт бичигт 1 удаагийн өөрчлөлт оруулсан ч оны төгсгөлд гүйцэтгэгч шалгарч санхүүжилт татагдсан тул гэрээ байгуулагдаагүй.
- Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол болон ерөнхий боловсролын сургуулийн номын фонд, тоног төхөөрөмж /Ховд, Хөвсгөл/: Ажлын даалгавартай холбоотой шалгарсан компани нь өөрөө гомдол гаргасан, ХАА зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулсан хэдий ч гэрээ байгуулахад хуулийн байгууллагад гомдол гарсан тул гэрээ байгуулагдахгүй явсаар санхүүжилт татагдсан.
- Баруун бүсийн хүүхэд, залуучуудын хүрээлэнгийн тоног төхөөрөмж /Ховд, Жаргалант сум/: Худалдан авах ажиллагааг 6 удаа зарлаж, 5 дахь удаагийн худалдан авах ажиллагааны даа гүйцэтгэгчтэй гэрээ байгуулах эрх олгосон. Гэвч ажлын даалгаварт тусгасан угсарч суурилуулах ажлын нөхцөлийг гүйцэтгэгч зөвшөөрөөгүйгээс гэрээ байгуулаагүй, 6 дахь удаагийн худалдан авах ажиллагаагаар өөр гүйцэтгэгч шалгарсан ч оны эцэст мөнгө татагдсан шалтгаанаар гэрээ байгуулаагүй,
- Музейн, номын сангийн өргөтгөлийн барилга /Ховд, Дарви сум: Нэршил төсөвт өртөг уялдаагүйн улмаас худалдан авах ажиллагаа амжилтгүй болж гүйцэтгэгч шалгараагүй.

2.3.3 Тайлант онд зохион байгуулсан 62 багц худалдан авах ажиллагаанаас доорх 6 төсөл арга хэмжээний худалдан авах ажиллагаанд оролцогчид гомдол гаргаснаас 4 төсөл арга хэмжээний тендер шалгаруулалттай гомдлыг хэрэгсэхгүй болгон, 1 төсөл арга хэмжээний оролцогч гомдлоо буцаасан, 1 төсөл арга хэмжээний гомдол тайлант онд шийдвэр гараагүйгээс оны эцэст төсөв татагджээ.

Хүснэгт4: Гомдол гарч хууль, хяналтын байгууллагаар дамжсан ажлын жагсаалт сая.төг

№	ТАХ-ны нэр	төсөв т өртөг	Гэрээн ий дүн	Шалтгаан тайлбар
1	"Шинэ хөдөө" төсөл /Ховд/	600	559	АТГ гомдол гарч гомдол үндэслэлгүй болсноор тендер амжилттай болсон
2	Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж /Ховд, Жаргалант сум/	1,900	1,884	ШӨХТГ, АТГ, Сангийн яам гомдол гарсан ч эцсийн шатанд гомдол гаргагч гомдлоо татсанаар тендер амжилттай болсон

3	Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/	38,07 1	35,769	Гэрээ байгуулах шатандаа явж байна.
4	Соёлын салбарын тоног төхөөрөмж /Ховд/ Багц2: Компьютер тоног төхөөрөмж	512	409	Тендер амжилттай болов.
5	Цэцэрлэгийн барилга худалдан авах, 75 ор /Ховд, Жаргалант сум/	1,560	1,560	Гэрээ байгуулах шатандаа явж байна.
6	Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол болон ерөнхий боловсролын сургуулийн номын фонд, тоног төхөөрөмж /Ховд, Хөвсгөл/	100		Гомдол шийдэгдээгүй санхүүжилт татагдсан.
Дүн		42,74 3	40,181	

Эх сурвалж. Худалдан авах ажиллагааны тайлан, мэдээ

2.3.4 Тендерийн баримт бичигт өмнөх ажлын гүйцэтгэл шаардсан эсэхийг түүвэрчлэн хянахад 1 компанид хэд хэдэн ажил өгөх, хэд хэдэн багцад 1 компанид зэрэг шалгаруулснаар хөрөнгө оруулалтын ажлууд хугацаандаа хэрэгжихгүй байх эрсдэл үүсэж болзошгүй байна.

2.3.5 Тендерийн баримт бичигт шалгуур үзүүлэлтийг боловсруулахдаа салбарын онцлог, нийгэм, эдийн засгийн байдал, ижил төстэй ажлуудын зарласан тендерийн баримт бичгийг харгалзан үзээгүй байна. Аудитаар ижил төстэй, адилхан төсөвт өртөгтэй 2 ТАХ-г харьцуулан авч үзэхэд тендерийн шалгуурыг харилцан адилгүй тогтоосон, тэгш байдлыг хангаагүй нь байна.

2.3.6 Иймд тендерийн баримт бичиг боловсруулах нэг, ажлын даалгаврын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулж, үр дүнтэй зохион байгуулах талаар үнэлгээний хороог мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах шаардлагатай байна.

БҮЛЭГ 3. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ САНХҮҮЖИЛТИЙГ БОДИТ ГҮЙЦЭТГЭЛД ҮНДЭСЛЭН ОЛГООГҮЙ, ГЭРЭЭГ ХҮНДЭТГЭН ҮЗЭХ ШАЛТГААНГҮЙГЭЭР СУНГАЖ, ҮҮРЭГ ДААЛГАВРЫН БИЕЛЭЛТИЙГ ХАНГААГҮЙ БАЙХАД УЛСЫН КОМИСС АШИГЛАЛТАД ХҮЛЭЭН АВСАН БАЙНА

Зарим төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэлийг хянаагүй, санхүүжилтийг илүү олгосон, барьцаа хөрөнгийг хугацаанаас өмнө олгосон байна

3.1.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын эрх шилжсэн 34 ТАХ-ний 55,647.5 сая төгрөгийн санхүүжилт батлагдсанаас гүйцэтгэлээр 37,292.1 сая төгрөгийн санхүүжилт ирж, 18,355.3 сая төгрөгийн санхүүжилт дутуу ирсэн байна.

3.1.2 Тайлант онд тендер шалгаруулалт амжилтгүй болсон, удааширсан, гүйцэтгэгч гэрээнээс татгалзсан, төсөвлөлтийн шаардлага хангаагүй ТАХ баталсан, ажлын тоо хэмжээг оновчтой тусгаагүй зэрэг шалтгааны улмаас 9 төсөл арга хэмжээний 15,241.0 сая төгрөгийн санхүүжилтийг авч чадаагүй нь хөрөнгө оруулалтын хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулж ажиллаагүй байна. Үүнд:

Хүснэгт5: ТАХ-ны амжилтгүй болсон төслийн жагсаалт сая.төг

д/д	Төсөл арга хэмжээний нэр	Эхлэх	Дуусах	Санхүүжих дүн	Тайлбар
-----	--------------------------	-------	--------	---------------	---------

1	Баруун бүсийн хүүхэд, залуучуудын хүрээлэнгийн тоног төхөөрөмж /Ховд, Жаргалант сум/	2024	2024	1,000.0	ХАА-6 удаа зарлаж 2 ч гүйцэтгэгчийг шалгарсан. Шалгарсан гүйцэтгэгч нь угсарч суурилуулахгүй мөн олон удаа зарласантай холбоотойгоор хугацаа алдсан.
2	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Мөнххайрхан, Буянт, Мөст, Ховд, Эрдэнэбүрэн сум/ багц-5	2024	2024	200.0	8 удаа зарласан ч гүйцэтгэгч шалгараагүй, ажлын тоо хэмжээг оновчтой тодорхойлоогүй,
3	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Жаргалант сум/	2024	2024	1,500.0	ХАА 6 удаа зарласан. ТББ-т 3 удаагийн өөрчлөлт оруулсан. Оны төгсгөлд гүйцэтгэгч шалгарсан ч санхүүжилт татагдсан. Гэрээ байгуулагдаагүй.
4	Ховд хотын ундны усны хоёр дахь эх үүсвэр /Ховд, Жаргалант сум/	2024	2026	11,421.0	Гомдол гарч ТББ-н шалгуур үзүүлэлтэд өөрчлөлт орж 2 удаа зарлаж, тайлант онд гэрээ байгуулж чадаагүй
5	Хөдөөгийн багуудад мотоцикл олгох	2024	2024	120.0	
6	Музейн, номын сангийн өргөтгөлийн барилга /Ховд, Дарви сум/	2024	2024	200.0	Нэршил төсөвт өртөг уялдаагүйн улмаас ХАА амжилтгүй болж гүйцэтгэгч шалгараагүй.
7	Буянт сум дахь Ховд агро парк төслийн газарт услалтын системийн толгойн байгууламж 1000 метр хар хоолойн угсрах ажил	2024	2024	200.0	4 удаа зарласан ч гүйцэтгэгч шалгараагүй, ХАА-г үр дүнтэй зохион байгуулаагүй
8	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Зэрэг, Мянгад, Буянт, Ховд, Чандмань, Архангай, Өгийнуур сум/	2024	2024	500.0	4 удаа тендер зарласан боловч гүйцэтгэгч ороогүй,ХАА-г үр дүнтэй зохион байгуулаагүй
9	Дэлхийн шилдэг хүүхдийн зохиол болон ерөнхий боловсролын сургуулийн номын фонд, тоног төхөөрөмж /Ховд, Хөвсгөл/	2024	2024	100.0	ХАА зарлаж гүйцэтгэгчийг шалгаруулсан хэдий ч гомдол гарч хуулийн байгууллагад шалгагдаж, гэрээ байгуулаагүй тул санхүүжилт татагдсан.
ДҮН				15,241.0	

Эх сурвалж:ХААГ-ын тайлан, мэдээ-2024

3.1.3 Эрх шилжсэн 34 төсөл арга хэмжээний 37,292.1 тэрбум төгрөгийн санхүүжилт орж ирснээс 29,319.8 тэрбум төгрөгийг олгож, 7,972.4 тэрбум төгрөгийн барьцаа дансанд шилжүүлсэн байна.

3.1.4 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тухайн жилд төлөвлөсөн санхүүжилтийг ССАЖЗС, ЭМС, ГБХНХС нь тус тус 100 хувь буюу бүрэн ашигласан бол ЗТЯС 49 хувьтай, ХХААХҮС 65 хувьтай, МУСЗГХЭГД 63 хувьтай буюу хэрэгжилт хангалтгүй байна.

3.1.5 Төлөвлөсөн зарим ТАХ-ний санхүүжилтийг тодорхой нөхцөл, шалгуур үзүүлэлтгүйгээр барьцаа хөрөнгийн дансанд байршуулж, дараагийн онуудад санхүүжүүлж байгаа нь Төсвийн тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.5-д “Төсвийн захирагч нь энэ хуулийн 43.1.3 , 43.1.5 -д зааснаас бусад төсвийг хоёр төсвийн жил дамжуулан зарцуулахгүй” заалттай нийцэхгүй байна.

3.1.6 Хөрөнгө оруулалтын зарим төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлд үндэслээгүй илүү олгосон, зураг төслөөс өөрчилж гүйцэтгэсэн тохиолдолд

өөрчлөлтийн зураг төсвийг гаргуулж зохиогч, захиалагчаар хянуулаагүй, ажлын гүйцэтгэлд өөрчлөлт оруулсан бодит гүйцэтгэлээр бус анхны зураг, төсвийн дүнгээр тооцож гаргасныг баталгаажуулж, санхүүжүүлсэн байна. Тухайлбал:

- ХББОСС-ын багцын 1200.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "3х3" сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл /Ховд/ ажлын бодит гүйцэтгэлийг хянаагүйгээс санхүүжилтийг 282.0 сая төгрөгөөр илүү,
- Боловсролын сайдын багцын Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/ ТАХ-ний барилгын гадна ханыг зураг төсөлд өнгөлгөөний тоосгоор хийх байсныг 12 ханаар хийж гүйцэтгэн, санхүүжилтийг 142.5 сая төгрөгөөр илүү,
- Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, Малчны хороолол ажлын бодит гүйцэтгэлийг хянаагүйгээс 357.6 сая төгрөгөөр илүү,
- Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Чандмань багц 5/-ын ажлын гүйцэтгэлийн санхүүжилтийг 60.9 сая төгрөгөөр илүү,
- Жаргалант сумын 240 ортой хүүхдийн 9-р цэцэрлэгийн ажлыг гүйцэтгэсэн Ган бүрэн ХХК нь дулааны тоолуур суурилуулаагүй, гадна тохижилтын ажлыг гүйцэтгээгүй байхад хүлээн авч санхүүжилт бүрэн олгосон,

3.1.7 Эдгээр зөрчлүүд нь захиалагч болон зохиогч нь ТАХ-ний гүйцэтгэлийг баталгаажуулж санхүүжүүлэхдээ бодит гүйцэтгэлд үндэслэхгүй байгаа нь Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журмын 4.8.12-д "Төсөл, арга хэмжээний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгоно" гэж заасныг зөрчсөн тул хариуцлага тооцуулах албан шаардлагыг ТЕЗ-д хүргүүллээ.

3.1.8 ХОХБТХ нь "3х3" сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл /Ховд/ ТАХ ний зураг төсөл боловсруулах гэрээг байгуулахдаа нэг зурагтай ажлыг холболтын зураг төслийг иж бүрэн зураг төслийн үнээр тооцон 55.0 сая төгрөгөөр илүү санхүүжилт олгосон, зураг төсөл боловсруулах гэрээг 4 хуваан шууд гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1¹⁴, ТБОНӨХБАҮХАТ хуулийн 10 дугаар зүйлийн 10.3¹⁵-д заасныг зөрчсөн тул хуулийн байгууллагад шалгуулахаар шийдвэрлэлээ.

3.1.9. Аудитын явцад иргэдээс ирүүлсэн мэдээлэлд үндэслэн нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхэд албан тушаалтантай холбоотой ашиг сонирхлын зөрчил үүссэн байж болзошгүй зөрчил илэрсэн тул хуулийн байгууллагад шалгуулахаар шийдвэрлэв.

Захиалагч нь хугацаандаа хэрэгжээгүй төсөл арга хэмжээний гэрээг дүгнээгүй, гэрээг цуцлах, гүйцэтгэлийн баталгааг төсөвт төвлөрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүйгээс төсвийн хөрөнгийн үр өгөөжийн буурсан зөрчил арилахгүй байна

3.2.1 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын 66 төсөл арга хэмжээнээс 34 төсөл арга хэмжээг 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар, 32 төсөл арга хэмжээ нь он дамжин хэрэгжүүлэхээр төлөвлөн баталсан байна.

3.2.2 Эрх шилжиж ирсэн 35 ТАХ-ээс 25 ТАХ-ний 54 багц ажлыг 2024 онд хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөснөөс 35 багц төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 12 багц төсөл арга хэмжээ төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, 7 багц төсөл арга хэмжээ хэрэгжиж эхлээгүй.

¹⁴ "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах"

¹⁵ "Захиалагч шууд худалдан авах, харьцуулалтын аргыг хэрэглэх зорилгоор батлагдсан төсөвт өртгийг хувааж худалдан авах ажиллагаа зохион байгуулахыг хориглоно"

3.2.3 Хугацаандаа хэрэгжиж дуусаагүй төсөл арга хэмжээнүүд нь гэрээг оройтож байгуулсан, ажлыг зураг төсвийн дагуу хийж гүйцэтгээгүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн төсөл арга хэмжээ төлөвлөснөөс санхүүжилт олгогдохгүй удааширсан зэрэг шалтгаануудаас 22,606.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээнүүд төлөвлөсөн хугацаандаа хэрэгжээгүй, захиалагч гэрээг дүгнэж ажиллаагүй байна.Үүнд:

Хүснэгт 6: Хугацаандаа хэрэгжээгүй төсөл арга хэмжээ
сая.төг

ДД	Төсөл, арга хэмжээний нэр	Эхлэх он	Гэрээний үнийн дүн	Шалтгаан
1	Малын гаралтай түүхий эдийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмж /Ховд, Жаргалант сум/	2024	1,883.7	Тоног төхөөрөмж суурилуулах ажил хүлээгдэж байгаа.
2	Цахилгаан хангамж /Ховд, Булган сум/	2024	1,431.3	Улсын комиссын үүрэг даалгавар өгч, хүлээн аваагүй
3	"3х3" сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл /Ховд/	2024	1,199.2	Гэрээг оройтож байгуулсан
4	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт багц 2. Буянт сум	2024	195.9	Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчсөн төсөл арга хэмжээ тул санхүүжилт удааширсан
5	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт багц 3. Мөст сум	2024	198.6	
6	Ногоон байгууламж бүхий орчны тохижилт багц 4. Ховд сум	2024	199.4	
7	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/ багц 2	2024	749.0	Гэрээг оройтож байгуулсан
8	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/ багц 9	2024	296.0	Урсгал зардлыг санхүүжүүлэх арга хэмжээ тул эрх
9	Орон нутгийн хөгжлийг дэмжих "Шинэ хөдөө" төсөл /Ховд/ багц 10	2024	995.7	Гэрээг оройтож байгуулсан
10	Бага сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга /Ховд, Жаргалант сум, 12 дугаар баг, Малчны хороолол/	2022	5,046.5	Гэрээг хүндэтгэн үзэх шалтгаангүй сунгасан
11	Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/	2022	7,226.7	Үе шатны ажлын хуваарийн дагуу ажлаа гүйцэтгээгүй
12	Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/	2022	3,184.9	Гэрээг хүндэтгэн үзэх шалтгаангүй сунгасан
Нийт			22,606.8	

Эх сурвалж:УТХО-ын 2024 оны судалгаа

3.2.4 Захиалагч, гүйцэтгэгчтэй байгуулсан ажил гүйцэтгэх гэрээ, худалдан авах гэрээг 1-3 удаа сунгахдаа гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйлийг хэрхэн үнэлж гэрээг сунгасан талаарх нотлох баримт хангалтгүй, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр 14.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 10 ажлын гэрээг сунгаж, 2025 онд хүлээлгэн өгөхөөр байгуулсан нь холбогдох гэрээнд заасан “Гүйцэтгэгч нь ажил дуусахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон бол алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн дүнгийн 0.5 хувь байна” гэсэн заалттай нийцээгүй байна.

3.2.5 Захиалагч нь гэрээний үүргээ хугацаанд нь хэрэгжүүлээгүй гүйцэтгэгчид хариуцлага тооцох, хугацаатай үүрэг чиглэл өгөх, гэрээг цуцлах, гүйцэтгэлийн баталгааг төсөвт төвлөрүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж ажиллаагүй зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

3.2.6 ГХБХБГ-аас улсын төсвийн хөрөнгө оруулалтын ажил зогссон, удааширсан төсөл арга хэмжээний гүйцэтгэгч байгууллага болон захиалагчид албан бичгийг тухай

бүр гарган хүргүүлж ажилласан байна.

3.2.7 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 16 ТАХ-ний 843.9 сая төгрөгийн чанарын баталгааг хугацаанаас нь өмнө барьцаа данснаас чөлөөлсөн нь Барилгын тухай 14.3¹⁶, 14.6¹⁷ -дах заалтууд болон ажил гүйцэтгэх гэрээний холбогдох заалтуудтай нийцээгүй байна.

3.2.8 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын хугацаандаа хэрэгжээгүй шалтгаан, нөхцөлийг тодорхойлж, гэрээг дүгнэн үргэлжлүүлэн санхүүжүүлэх, эсвэл цуцалж хариуцлага тооцох зэргээр цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээг тодорхойлох, шаардлагатай санхүүжилтийг ирэх онуудын төсөвт тусгах замаар хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах шаардлагатай байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт сул, үүрэг даалгаврын биелэлтийг хангаагүй байхад улсын комисс ашиглалтад хүлээн авсан байна.

3.3.1 Тайлант онд хугацаандаа бүрэн хэрэгжсэн 14,327.1 сая төгрөгийн гэрээний дүнтэй 35 төсөл арга хэмжээнээс шинээр хэрэгжих 28, шилжин хэрэгжих 7 төсөл арга хэмжээг ашиглалтад хүлээн авсан байна.

3.3.2 Ашиглалтад хүлээн авсан 35 ТАХ-ны 28 хувь буюу 9,509.9 сая төгрөгийн 10 ТАХ барилга, байгууламж, 72 хувь буюу 5,196.7 сая төгрөгийн 25 ТАХ тоног төхөөрөмж тус тус эзэлж байна.

3.3.3 Хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн зарим машин, техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үзүүлэлтүүд стандарт, техникийн тодорхойлолт заасан шаардлагад нийцээгүй байна.

3.3.4 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн зарим барилга байгууламжийн хүлээн авахдаа ажлын тоо хэмжээ дутуу, зураг төсвийн дагуу бүрэн хийгээгүй ТАХ болон өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хангаагүй байхад улсын комисс хүлээн авсан зөрчил нийтлэг байна.Үүнд:

- *Сумын төвийн хатуу хучилттай авто зам /Ховд, Жаргалант сум, Баатархайрхан, Бичигт баг/-ын ажлын зурагт тусгасан ус зайлуулах шүүрүүлэх суваг, хоолой 8 ширхэг худаг хийх ёстойг хийгээгүй,*
- *Мөст суманд барьсан түүхий эдийн төвийн барилгын гадна тохижилтын ажлуудаас хогын сав, сандал, ногоон байгууламж хийгдээгүй,*
- *Багийн хөгжлийн дэмжих хөтөлбөр 2023 оны УТХО ажлаас гэрээг сунган он дамжин хэрэгжсэн 6 дугаар багц буюу Чандмань сумын тохижилтын ажлаас 6 ажил дутуу хийгдсэн байхад улсын комисс хүлээн авсан,*
- *Иргэдэд үйлчлэх мэдээллийн төвийн барилга /Ховд, Манхан сум/ - гадна хашаа, ногоон байгууламж хийгээгүй,*
- *"3х3" сагсан бөмбөгийн талбайн тохижилт, шинэчлэл /Ховд/- Хашааны суурийн зургийн дагуу хийгээгүй, Цэцэг сум, Мөст сум, Дарви сум, Дуут сум байршлыг оновчтой газар төлөвлөөгүй,*
- *Ногоон байгууламж бүхий орчны тохижилт /Ховд, Мөнххайрхан, Буянт, Мөст, Ховд, Эрдэнэбүрэн сум/- Мөст, Ховд сумын тохижилтын ажлыг Шинэ төгс шийдэл ХХК гэрээний хугацаанд хийж гүйцэтгээгүй, ажил дутуу,*

¹⁶ Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил байна.

¹⁷ Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

- *Багшийн хөгжлийн төвийн барилга /Ховд, Жаргалант сум/- 2024 онд үе шатны ажлын хуваарийн дагуу ажлаа гүйцэтгээгүй, ажил зогссон,*
- *Дотуур байрны барилга, 150 ор /Ховд, Манхан сум, Төгрөг гол баг/- гадна ханыг зураг төсвийн дагуу хийгээгүй,*
- *Барилгын улаан журнал бүрэн хөтлөөгүй , ил далд ажлын актыг бичиж баталгаажуулсан он сарыг бөглөөгүй, бэлтгэн нийлүүлэгчээс нийлүүлсэн материал хийц, эдлэлийн марк, чанар, нэр төрлийг хэрхэн шалгаж хүлээн авсан падаан, паспорт, сертификатын дугаар тавиагүй,*

3.3.5 Дээрх зөрчлүүд нь зохиогчийн болон захиалагчийн хяналтыг хэрэгжүүлж байгаа байгууллага, гэрээнд заасны дагуу хяналтыг үр дүнтэй хэрэгжүүлээгүйгээс шалтгаалжээ.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 2,122.9 сая төгрөгийн төсөл арга хэмжээг бүртгэлд тусгаагүй, зарим төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүйгээс ашиглалт хангалтгүй байна

3.4.1 Тайлант онд хэрэгжиж дууссан 6,940.3 сая төгрөгийн 24 ТАХ-г 8 төсөвт байгууллагын үндсэн хөрөнгө болон бараа материалын дансанд холбогдох шийдвэрийн дагуу бүрэн бүртгэсэн байна.

3.4.2 Улсын комисс ажиллаж хүлээн авсан 6 ТАХ-ний 2,122.9 сая төгрөгийн хөрөнгийг данс бүртгэлд тусгах шийдвэр гараагүйгээс бүртгэлд тусгаагүй байна.

3.4.3 УТХО-аар 2023 онд хэрэгжсэн Шинэ хөдөө 1 төслөөр ирсэн 4,650.0 сая төгрөгийн хөрөнгүүдийг эрх бүхий байгууллагын шийдвэргүйгээр Шинэ Ховд ББХК ОНӨААТҮГ-аас гэрээ байгуулан сумуудын тамгын газар, ААН, иргэдэд олгосон нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1.24¹⁸-д заасантай нийцэхгүй байна. Үүнд:

- *Шинэ Ховд ББХК ОНӨААТҮГ нь “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ Хөдөө төсөл” Багц 1-Хөдөө аж ахуйн газар тариалангийн 2,940.8 сая төгрөгийн тоног төхөөрөмж, багц 2 -Хөдөө аж ахуйн хөнгөн үйлдвэрийн 1,092.9 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг 17 сумын тамгын газарт гэрээгээр 3,447.8 сая төгрөгийн хөрөнгийг эзшүүлсэн, үлдсэн 460.2 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг өөрийн эзэмшилд үлдээсэн байна. Тус багцуудын тоног төхөөрөмжийн ашиглалт сум бүрд харилцан адилгүй байгаа бөгөөд зарим нь ашиглалтгүй хадгалагдаж байна.*
- *“Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ Хөдөө төсөл” Багц 3-Хөдөө аж ахуйн гаралтай хүнсний бүтээгдэхүүн боловсруулах 385.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж 138 иргэн ААН-үүдэд олгосон*
- *“Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ Хөдөө төсөл” Багц 4. Хүлэмжийн аж ахуйн төгрөгийн тоног төхөөрөмжөөс 28 ширхэг 98.0 сая төгрөгийн зөөлөн бороожуулах услалтын систем 28 иргэн ААН-дэд олгосон.*
- *Багийн хөгжлийн дэмжих хөтөлбөр 2023 оны УТХО хэрэгжсэн 2 дугаар багцын буюу Зэрэг сумын тохижилтын ажлууд чанаргүй хийгдсэнээс эвдэрч ашиглах боломжгүй болсон./ Гэрлэн дохио, явган хүний зам, Урд ойн төгөл хашаажуулах, цаг, цаг агаар, мэдээ мэдээллийн цамхаг гэх мэт/*

¹⁸ "Төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг;

3.4.4. Барилга байгууламж, техник тоног төхөөрөмжийг бүрэн хүчин чадлаар ашиглаагүй нийлүүлсэн тоног төхөөрөмжийн эзэмшигч нь тодорхой бус ашиглалтгүй, хадгалагдаж байгаа нь төсвийн хөрөнгийн үр дүнг бууруулж байна.Үүнд:

- Эрүүл мэндийн тоног төхөөрөмж төсөл арга хэмжээг төлөвлөхдөө сумдын эрүүл мэндийн төвүүд нь 10 орны хүчин чадалтай байхад 50 л багтаамжтай 1, 2-р хоолны тогоо, жигнүүр бэлтгэсэн нь ашиглагдахгүй байгаа,
- Соёлын тоног төхөөрөмж төсөл арга хэмжээнээс бэлтгэсэн сумдын Соёлын төвөөс багийн дарга нарт караокены төхөөрөмжийг сумдын баг бүрт 79 ширхэг
- хүлээлгэн өгсөн боловч эд хөрөнгийн хариуцлагын гэрээ байгуулж олгоогүй.
- Соёлын салбарын тоног төхөөрөмж “багц”-ын ажлаас аймгийн Хөгжимт драмын театрт нийлүүлэгдсэн 41 сая төгрөгийн тоног төхөөрөмж хувь хүн, хамтлагт хүлээлгэн өгсөн, ашиглалтын гэрээ хийгээгүй.
- “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ Хөдөө төсөл”-өөх хэрэгжсэн ирсэн 34 морины хүчтэй трактор дагалдах хэрэгслийг Булган, Үенч, Дөргөн, Мөст, Цэцэг, Мянгад, Алтай, сумууд ашиглаагүй хадгалж байна.
- “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ Хөдөө төсөл”-өөх хэрэгжсэн ирсэн 34 морины хүчтэй трактор дагалдах хэрэгслийг Жаргалант, Мөнххайрхан, Дуут, Манхан, Эрдэнэбүрэн, Чандмань сумууд бусдад гэрээгээр ашиглуулж байгаа
- “Орон нутгийн хөгжлийг дэмжих Шинэ Хөдөө төсөл”-өөх хэрэгжсэн ирсэн Ноосны пресс, ноосны пүүг Манхан, Мөст, Чандмань, Зэрэг Буянт сумууд иргэд болон хөдөө аж ахуйн нөхөрлөлд ашиглуулж байгаа бөгөөд бусад сумууд ашиглалтгүй байна.
- Жаргалант сумын II, IV, VI цэцэрлэгийн хуучин барилгыг буулгасан материалыг аймгийн ОНӨГ-аас хүлээн авсан боловч материал хүлээн авсан акт үйлдээгүй.
- Соёлын салбарын тоног төхөөрөмж төсөл арга хэмжээнээс бэлтгэсэн караокены төхөөрөмжид дуу суулгаагүй нийлүүлэгдсэн тул ашиглагдахгүй байгаа төв 1 төхөөрөмжид дуу суулгахад 2-3 сая төгрөгийн зардал гарахаар байгаа тул ашиглагдахгүй байгаа,

3.4.5 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын өмнөх оны аудитаар өгөгдсөн 427.6 сая төгрөгийн 5 төлбөрийн акт, 4,711.9 сая төгрөгийн 6 албан шаардлага, 4997.3 сая төгрөгийн 5 зөвлөмж, 2,184.3 сая төгрөгийн 1 хариуцлага тооцуулах албан шаардлага нийт 12,854.9 сая төгрөгийн зөрчилд аудитын шийдвэр гаргаж хүргүүлснээс хэрэгжилт хангагдаагүй дараах үлдэгдэлтэй байна.

3.4.6 Дээрх хүснэгтээс харахад шийдвэрийн хэрэгжилт 41.0 хувьтай байгаа бөгөөд ТЕЗ нь төрийн аудитын байгууллагаас гаргасан шийдвэрийг бүрэн биелүүлээгүй, шийдвэрийн хэрэгжилтийн хангах ажлын төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй, удирдлага арга зүйгээр хангаж, хяналт хэрэгжүүлээгүй, албан хаагчдын ажлын хариуцлага сул байгаа зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

ДҮГНЭЛТ:

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан 2 төсөл арга хэмжээг 2024 онд төлөвлөгөөгүй байна

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг аргачлалын дагуу үнэлж эрэмбэлээгүй, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлыг тооцож төлөвлөсөн эсэх нь тодорхой бус байна
- Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвлөлтийн шаардлага хангаагүй төсөл арга хэмжээг тусгасан, санхүүжих дүнг хэрэгжүүлэх хугацаатай уялдуулж төлөвлөөгүй байна
- Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж, 5,700.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл арга хэмжээг төлөвлөжээ
- Аймгийн Засаг даргад 91,558.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 22 төсөл арга хэмжээг 8 сайдын багцаас эрх шилжүүлж, 21 төсөл арга хэмжээг нээлттэй тендер шалгаруулалтаар зохион байгуулсан байна
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний тендерийн баримт бичгийг хууль, журам, стандартад нийцүүлэн боловсруулаагүйгээс зарим шаардлагагүй тоног төхөөрөмж нийлүүлжээ
- Тендерийн баримт бичиг, ажлын даалгаврын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулж, үр дүнтэй зохион байгуулаагүйгээс 15,241.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй төсөл арга хэмжээ хэрэгжих боломж алдагджээ
- Зарим төсөл, арга хэмжээний ажлын бодит гүйцэтгэлийг хянаагүй, санхүүжилтийг илүү олгосон, барьцаа хөрөнгийг хугацаанаас өмнө олгосон байна
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд тавих хяналт сул, үүрэг даалгаврын биелэлтийг хангаагүй байхад улсын комисс ашиглалтад хүлээн авсан байна
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 7,766.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээг бүртгэлд тусгаагүй, зарим төсөл арга хэмжээний хэрэгцээ шаардлагыг оновчтой тодорхойлоогүйгээс ашиглалт хангалтгүй байна.

АУДИТЫН ЗӨВЛӨМЖ:

Гүйцэтгэлийн аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

Аймгийн Засаг дарга М.Амарсанаа танаа

- ✓ Зураг төсөвгүй, магадлалаар баталгаажуулаагүй барилга байгууламж, төсөвлөлтийн шаардлагад нийцээгүй төсөл арга хэмжээг төлөвлөхгүй байх
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцээгүй төсөл арга хэмжээг улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөхгүй байх.
- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн ажлуудад тавих захиалагчийн хяналтын үр нөлөөг дээшлүүлэн, зураг зохиогч болон захиалагчийн гэрээний хэрэгжилтэд тавих дотоод хяналтыг сайжруулан ажиллах
- ✓ Барьцаа данснаас чанарын баталгааг хугацаанаас өмнө чөлөөлж байгаа зөрчлийг арилгаж, Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн холбогдох заалтад нийцүүлэн гэрээ байгуулж байх

Санхүү төрийн сангийн хэлтсийн даргын түр орлон гүйцэтгэгч Г.Батсайхан танаа

- ✓ Хөрөнгө оруулалтын ажлуудын чанарын баталгааг гэрээнд заасан хугацаанаас нь өмнө чөлөөлөхгүй байх

Хөгжлийн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Б.Гомбосүрэн танаа

- ✓ Төсөл арга хэмжээний саналыг төсвийн төсөлд тусгуулахаар хүргүүлэхдээ хууль, журам болон аргачлалд заасан шалгуур үзүүлэлтээр үнэлж, эрэмбэлэн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг цахим системээр бүрэн тайлагнаж Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоол болон Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан заавар аргачлалыг мөрдөж ажиллах
- ✓ Ажлын даалгаврын шалгуур үзүүлэлтийг нарийвчлан боловсруулж, холбогдох өөрчлөлтийг тухай бүр оруулж, үр дүнтэй зохион байгуулах
- ✓ Хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээг онцгой нөхцөл үүсээгүй байхад онцгой байдлын шийдвэрээр шууд гэрээ байгуулан, хэрэгжүүлж байгаа зөрчлийг таслан зогсоох.

Орон нутгийн өмчийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Энхбаяр танаа

- ✓ Хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжиж дууссан хөрөнгүүдийн баримт бичгийг бүрдүүлж уламжлан орлого авах шийдвэр гаргуулах, өмнөх онд хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн барилга байгууламжийн магадлалаар батлагдсан төсөвт өртгөөр дутуу орлого авсан хөрөнгийг нэмж залруулан өртөг нэмэгдүүлэх
- ✓ Буулгасан барилгаас гарсан цаашид ашиглах бололцоотой материалыг хүлээж авах, үнэ тогтоох ажлыг зохион байгуулах

Худалдан авах ажиллагааны газрын дарга Н.Эрдэнэцэцэг танаа

- ✓ Үнэлгээний хорооны гишүүдийг тендерийн баримт бичиг, ажлын даалгавар боловсруулах мэргэжил арга зүйгээр хангаж талаар сургалт зохион байгуулж ажиллах
- ✓ Тендерийн баримт бичигт шалгуур үзүүлэлтүүдийг харьцангуй байдлаар тавьж өгч байгаа байдлыг нь таслан зогсоох

ГХБХБГ -ын түр орлон гүйцэтгэгч Б.Шинэзориг танаа

- ✓ Барилгын улаан журналыг журамд заасны дагуу бүрэн бүрэн хөтлүүлж, хяналтыг үр нөлөөтэй хэрэгжүүлэх
- ✓ Үүрэг даалгаварын биелэлт өгч, хэрэгжилтийг хангуулаагүй байхад улсын комиссын дүгнэлтийг гаргадаг байдлыг таслан зогсоох

Аймгийн Боловсролын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Цэрэндаваа танаа

- ✓ Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн тоног төхөөрөмжийн нийлүүлэлтэд дотоод хяналт хэрэгжүүлэн, зөрчлийг арилгуулах арга хэмжээг хэрэгжүүлж ажиллах

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР